

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад заасан “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх” тухай төсвийн тусгай шаардлагын дагуу байгалийн баялгийн үр өгөөжөөс бий болох тухайн жилийн орлогыг тухайн жилдээ зарцуулах боломжтой байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүйн иргэдэд тэгш, шударга хүртээх тухай зохицуулалттай нийцэхгүй байна.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар, улмаар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах болон зарцуулах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар манай улс 2010 оноос төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх төсвийн тусгай шаардлагыг Төсвийн тогтвортой байдлын хуульд тусгаж, хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр дээрх тусгай шаардлагыг агуулгыг өөрчилж, байгалийн баялгийн үр өгөөжийг зөвхөн өнөө цагт зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн агуулгатай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1."төсвийн тусгай шаардлага" гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг; гэж заасан

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11."нэгдсэн төсөв" гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг; Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан. Дээрх хуулийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогод баримтлах тусгай шаардлага нь Үндсэн хуульд нийцэх учиртай. Иймээс ч төсвийн тусгай шаардлагыг өөрчилсөн хуулийн өөрчлөлтийг эргэн харж, байгалийн баялгаас хамааралтай хязгааргүй өсөн нэмэгдэх зарлагын өсөлтийг хязгаарлаж, ирээдүйн цагийн иргэдийн боломжийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Тус хуулийн төсөлтэй холбоотой Улсын Их Хурлын цахим хуудас D.parliament.mn сайтад байршуулан санал авсан бөгөөд тухайлан санал ирүүлээгүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар байгалийн баялгаас хамааралтай төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийг үр ашигтай зарцуулах замаар улс орны эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан, өнөө болон ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилго хангагдана.

---oOo---